ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ



2026 July

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

АГУУЛГА

I. СТАТИСТИКИЙН ТОЙМ 1

II. ГАДААД ЭДИЙН ЗАСАГ 2

2.1. Олон улсын эдийн засаг 2

2.2. АНУ-ын эдийн засаг 2

2.3. БНХАУ-ын эдийн засаг 3

2.4. Түүхий эдийн зах зээл 3

III. ДОТООД ЭДИЙН ЗАСАГ 6

3.1. Эдийн засгийн өсөлт 6

3.2. Инфляц 7

3.3. Улсын төсөв 8

3.4. Мөнгөний нийлүүлэлт 8

3.5. Нийт зээл 9

3.6. Гадаад худалдаа 10

3.7. Төлбөрийн тэнцэл, ханш 13

График, хүснэгтүүдийн жагсаалт

График 1 АНУ-ын эдийн засгийн өсөлт 2
График 2 БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 3
График 3 Монгол улсын эдийн засгийн өсөлт 6
График 4 Инфляц ба Бодлогын хүү 7
График 5 Улсын төсөв 8
График 6 Мөнгөний нийлүүлэлт 9
График 7 Банкны салбарын зээл 10
График 8 Нийт экспорт, импорт 10
График 9 Экспортын голлох бүтээгдэхүүн 11
График 10 Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ, үнийн түвшин, 2026 6-р сар 11
График 11 Чулуун нүүрсний экспортын биет хэмжээ, үнийн түвшин, 2026 6-р сар 12
График 12 Импортын голлох бүтээгдэхүүн 13
График 13 Төлбөрийн тэнцэл 13

I. СТАТИСТИКИЙН ТОЙМ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026Q1	**2025Q4**	**2025Q1**	
Бодит ДНБ	тэрбум төгрөг	6,736	34,332	6,245	7.9%
Ажилгүйдлийн түвшин	%	5.7%	5.6%	5.4%	
Дундаж нэрлэсэн цалин	мянган төгрөг	2,921	2,852	2,622	11.4%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026M6	**2026M5**	**2025M6**	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам.доллар	10,394	8,471	6,581	57.9%
Зэс	сая ам.доллар	4,646	3,807	2,352	97.5%
Нүүрс	сая ам.доллар	3,942	3,201	2,557	54.1%
Нийт импорт	сая ам.доллар	6,117	4,905	5,528	10.7%
Хэрэглээ	сая ам.доллар	1,726	1,375	1,072	-9%
Хөрөнгө оруулалт	сая ам.доллар	2,435	1,878	2,215	10%
Аж үйлдвэрлэл	сая ам.доллар	582	469	429	36%
Шатахуун	сая ам.доллар	1,363	1,174	1,309	39%
Тэнцэл	сая ам.доллар	4,277	3,565	1,053	3.1x
Түүхий эдийн үнэ (Primary Commodity Prices, IMF, Монголбанк)					
Зэс	$/тонн	13,808	13,484	9,706	42%
Нүүрс (хилийн)	$/тонн	74	72	62	19%
Алт	$/трой унц	4,092	4,578	3,353	22%
Газрын тос	$/баррел	98	106	67	46%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026M6	**2026M5**	**2025M6**	
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	тэрбум төгрөг	-2.144	-1,351	-758	182.8%
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого	тэрбум төгрөг	14,630	11,672	13,215	10.7%
Төсвийн нийт зарлага	тэрбум төгрөг	16,773	13,023	13,973	20.0%
Мөнгөний бодлого					
М2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	53,445	51,700	42,230	26.6%
ХҮИ (С2023)	индекс	128.4	127.1	114.6	12.0%
Бодлогын хүү	%	12%	12%	12%	-
Хүү ба ханш					
Нэрлэсэн ханш (хугацааны эцэст)	Төгрөг/$	3,576	3,576	3,573	0.1%
Төгрөгийн хадгаламж (тухайн сард шинээр татсан)	%	11.07%	11.75%	11.59%	-4.5%
Валютын хадгаламж (тухайн сард шинээр татсан)	%	3.57%	4.24%	3.31%	7.9%
Төгрөгийн зээл (Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү)	%	17.59%	17.50%	17.27%	1.85%
Валютын зээл (Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү)	%	11.71%	10.34%	11.20%	4.55%
Гадаад валютын нөөц					
Нийт	сая ам.доллар	7,733	7,327	5,194	48.9%

II. ГАДААД ЭДИЙН ЗАСАГ

2.1. Олон улсын эдийн засаг

Олон улсын валютын сан (ОУВС)-ийн төсөөллөөр дэлхийн эдийн засгийн өсөлт өмнөх хоёр жилийн дунджаас буурч, 2026 онд 3.0 хувь, 2027 онд 3.4 хувь байх төсөөлөлтэй байна. Ойрхи Дорнод дахь дайны нөхцөл байдал нь өсөлтийн төлөвийг бууруулах гол нөлөөг үзүүлж байгаа хэдий ч хиймэл оюун ухааны хөгжүүлэлт, хэрэглээ хурдацтай нэмэгдсэнээр дэлхийн технологийн салбарын эрэлт өсөж буй нь дайны сөрөг нөлөөг хэсэгчлэн бууруулж өсөлтийг тэтгэх нөлөөтэй байна. Тодруулбал эрчим хүч экспортлогч орнууд газрын тосны өндөр үнийн үр өгөөжийг хүртэж байгаа бол технологийн салбарт оролцоо багатай, эрчим хүч импортлогч орнуудын өсөлт сулрах төлөвтэй байгаа юм.

Дэлхийн эдийн засагт үнийн дарамт эрчимжиж, инфляцын төсөөлөл өмнөх төсөөллөөс нэмэгдэн 2026 онд 4.7 хувь буюу өмнөх оны түвшнээс 0.6 нэгж хувиар нэмэгдэхээр байна. Үүнд геополитикийн эрсдэл өндөр хэвээр байгаатай холбоотойгоор эрчим хүчний зах зээл дэх үүсээд буй үнийн савлагаа, мөн тээврийн зардал болон нийлүүлэлтийн сүлжээний доголдлоос шалтгаалсан хүнсний үнийн өсөлт зэрэг нь голлон нөлөөлж байгаа юм. Харин 2027 онд төв банкуудын бодлогын төлөв болон эрчим хүчний үнэ тогтворжих зэрэг нөлөөгөөр инфляц 3.9 хувь хүртэл буурах төлөвтэй байна.

Ийнхүү ОУВС-ийн зүгээс геополитикийн эрсдэл, түүхий эдийн үнийн савлагаа болон инфляцын дарамт өндөр хэвээр байгаа нөхцөлд улс орнууд үнийн тогтвортой байдлыг хангах, төсөв санхүүгийн нөөц боломжийг бэхжүүлэх, эрчим хүчний хангамжийн эрсдэлийг бууруулах, мөн технологи, хиймэл оюун ухаанд суурилсан бүтээмжийн өсөлтийг дэмжих бодлогод анхаарах шаардлагатай байгааг онцолж байна. (IMF, 2026)

2.2. АНУ-ын эдийн засаг

График 1 АНУ-ын эдийн засгийн өсөлт



Эх сурвалж: U.S. Bureau of Labor Statistics

2026 оны 6 дугаар сард АНУ-ын эдийн засагт инфляцын дарамт буурч, эдийн засгийн өсөлт тогтвортой хадгалагдсан боловч хөдөлмөрийн зах зээл болон гадаад худалдааны зарим үзүүлэлтүүд саарчээ. АНУ, Ираны хоорондын гал зогсоох тохиролцооны дараа эрчим хүчний зах зээл тогтворжиж, газрын тосны үнийн дарамт багассанаар жилийн инфляц 3.5 хувь, суурь инфляц 2.6 хувь болж буурсан нь эдийн засагт эерэг дохиог бий болгосон. Гэсэн хэдий ч ажилгүйдлийн түвшин 4.2 хувьтай гарч ажиллах хүчний оролцооны түвшин 61.5 хувь болж буурсан нь хөдөлмөрийн захын идэвх суларч байгааг илтгэж байна.

Ийнхүү ХНБ-ны зүгээс бодлогын хүүг 3.5-3.75 хувьд хэвээр хадгалах шийдвэр гарсан ба дараагийн бодлогын хүүний шийдвэр 7 сарын 28-29-ий хооронд гарах хүлээлттэй байна.

Харин гадаад худалдааны хувьд гадаад эрэлт болон хөрөнгө оруулалтын идэвхтэй холбоотойгоор АНУ-ын экспорт өмнөх оны мөн үеэс 11.3 хувиар өссөн ч импорт илүү хурдацтай нэмэгдсэнээр нийт худалдааны тэнцэл 105.9 тэрбум ам.долларын алдагдалтай гарлаа. Ийнхүү эдийн засгийн өсөлтөд цэвэр экспортын үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдсэн бөгөөд холбооны төсвийн алдагдал тайлант сард 120 тэрбум ам.долларт хүрснээр эдийн засагт үзүүлэх төсвийн дарамт мөн нэмэгдээд байна.

2.3. БНХАУ-ын эдийн засаг

График 2 БНХАУ-ын эдийн засгийн өсөлт



Эх сурвалж: National bureau of statistics of China

БНХАУ-ын эдийн засгийн хувьд АНУ-тай харьцуулахад эсрэг дүр зурагтай байна. Тухайлбал, инфляц нам дор түвшинд буюу 1 хувьтай тэнцэж, харин экспортын өсөлт өндөр байгаагийн нөлөөгөөр худалдааны ашиг 126 тэрбум ам.долларт хүрсэн байна. Хэдийгээр дотоод эрэлт сул хэвээр байгаа ч үйлдвэрлэл, экспортын дэмжлэгээр эдийн засгийн тогтвортой өсөлтөө хадгалж, оны эхний хагаст 4.7 хувиар өссөн байна. Мөнгөний бодлогын хувьд Хятадын Ардын Банк бодлогын хүүгээ 3.0% түвшинд хадгалж, эдийн засгийн өсөлтийг дэмжихийн зэрэгцээ санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалах чиглэл баримталж байна. Харин төсвийн бодлогын хувьд дотоод эрэлтийг дэмжих зорилгоор төсвийн зарлагыг өндөрт хадгалснаар төсвийн алдагдал ойролцоогоор ДНБ-ий 6.5%-тай тэнцэх хэмжээнд хүрээд байгаа юм. Гэсэн ч үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжлэх, орон нутгийн засаг захиргааны өрийн дарамт зэрэг нь эдийн засгийн өмнө тулгарч буй гол сорилтууд хэвээр байна.

2.4. Түүхий эдийн зах зээл

Ойрх Дорнод дахь геополитикийн хурцадмал байдал болон дэлхийн эдийн засгийн тодорхой бус нөхцөлөөс шалтгаалан түүхий эдийн зах зээл өндөр хэлбэлзэлтэй байна. Эрчим хүчний нийлүүлэлтийн эрсдэл нэмэгдэж, үйлдвэрлэл болон тээвэрлэлтийн зардал өссөнөөр олон төрлийн түүхий эдийн үнэ өндөр түвшинд хадгалагдаж байгаа юм. Үүний зэрэгцээ эрчим хүчний шилжилт болон технологийн салбарын өсөлт нь зарим ашигт малтмалын эрэлтийг нэмэгдүүлж байна.

Цаашид зах зээлд тодорхойгүй байдал үргэлжлэх боловч 2027 онд нийлүүлэлтийн нөхцөл аажмаар сайжирч, түүхий эдийн үнийн өсөлт саарах төлөвтэй байна. Гэсэн хэдий ч геополитикийн эрсдэл, худалдааны бодлогын өөрчлөлт зэрэг хүчин зүйлс нь зах зээлийн төлөвт голлон нөлөөлсөөр байх юм.

Хүснэгт 1 Түүхий эдийн үнийн төсөөлөл

Түүхий эд	Спот үнэ*	2026Q3	2026Q4	2027Q1	2027Q2	2026	2027
Брэнт газрын тос, $/баррель	$98	$90	$83	$80	$78	$89	$77
Зэс, $/тонн	$13,808	$13,781	$13,794	$13,769	$13,757	$13,484	$13,752
Алт, $/унц	$4,092	$4,142	$4,170	$4,246	$4,294	$4,402	$4,318
Австралийн эрчим хүчний нүүрс, $/сая тонн	$226	$224	$227	$230	$233	$231	$234

*2026 оны 7-р сарын 24-ний байдлаар
Эх сурвалж: Bloomberg Terminal, World Bank

Алт: Алтны үнэ 2026 оны эхээр нэг унц нь $5,000-оос давж, түүхэн дээд түвшинд хүрсэн боловч 6-р сарын байдлаар оны эхэн үетэй харьцуулахад ойролцоогоор 6.8%-иар буураад байна. Хагас жилийн хугацаанд газрын тосны үнэ өссөнөөр инфляцын эрсдэл нэмэгдэж, АНУ-ын мөнгөний бодлого чанга хэвээр байх хүлээлт зах зээлд бий болж, улмаар ам.долларын ханш чангарч, бодит хүүгийн түвшин өссөн нь алтны ханшид дарамт үзүүлсэн. Геополитикийн тодорхой бус байдал болон төв банкуудын худалдан авалт алтны эрэлтийг нэмэгдүүлсээр байгаа бөгөөд 2026 оны хоёрдугаар хагаст алтны үнэ дунджаар $4,100 орчим унцын түвшинд хадгалагдаж, 2027 онд $4,318 түвшинд хүрэхээр таамаглагдаж байна.

Зэс: Зэсийн үнэ 2026 оны эхнээс хойш ойролцоогоор 9.4%-иар өсөж, цахилгаан, хиймэл оюун ухааны дата төвүүдийн хөрөнгө оруулалт болон цахилгаан автомашины үйлдвэрлэлийн өсөлтөөс шалтгаалан эрэлт өндөр хэвээр байна. Хагас жилийн хугацаанд зэсийн үнэ тонн тутамд $14,000-д дөхөж өссөн ч Хятадын аж үйлдвэрийн эрэлт харьцангуй сул байгаа нь үнийн өсөлтийг хязгаарласан. Түүнчлэн АНУ-аас боловсруулсан зэсэнд тариф ногдуулах асуудал богино хугацаанд тодорхойгүй байдал үүсгэж байна. Гэсэн хэдий ч уул уурхайн нийлүүлэлтийн хязгаарлалт, эрчим хүчний шилжилттэй холбоотой бүтцийн эрэлт үргэлжлэн нэмэгдэх төлөвтэй байгаа тул ойрын жилүүдэд нийлүүлэлтийн хомсдол хадгалагдаж, зэсийн үнэ 2026 оны төгсгөлд $13,484, 2027 онд $13,752 хүртэл өсөх төлөвтэй байна.

Газрын тос: Газрын тосны үнэ оны эхэн үетэй харьцуулахад ойролцоогоор 65%-иар өсөөд байна. Үнийн өсөлтөд АНУ-Ираны мөргөлдөөнөөс үүдэлтэй нийлүүлэлтийн эрсдэл, Ойрх Дорнодын бүс нутгийн геополитикийн хурцадмал байдал голлон нөлөөлж, оны эхний хагаст үнэ богино хугацаанд нэг баррель нь $100-оос давж өссөн. Харин 6-р сарын сүүлээс мөргөлдөөн намжих хүлээлт нэмэгдэж, Ормузын хоолойгоор газрын тосны урсгал аажмаар хэвийн болж эхэлснээр үнийн өсөлт саарч байна. 2026 оны хоёрдугаар хагаст газрын тосны үнэ дунджаар $85-90/баррелийн түвшинд хэлбэлзэх бөгөөд 2027 онд нийлүүлэлт нэмэгдэж, эрсдэл буурсан тохиолдолд аажмаар тогтворжих төлөвтэй байна. Гэсэн ч Ирантай холбоотой хурцадмал байдлаас шалтгаалж газрын тосны зах зээлд эрсдэл өндөрт хадгалагдсаар байна.

Нүүрс: 2026 оны эхний хагаст Австралийн коксжих нүүрсний үнэ өндөр хэлбэлзэлтэй байж, оны эхэнтэй харьцуулахад 6-р сард 17.5%-иар өсөж 258 ам.долларт хүрсэн байна. Үнийн өсөлтөд Австралийн уурхайн нийлүүлэлт түр саатсан, мөн Индонезын экспортын шинэ зохицуулалтын улмаас Азийн зах зээл дэх нүүрсний нийлүүлэлт

хумигдсан нь голлон нөлөөлсөн. Үүний зэрэгцээ Энэтхэгийн гангийн үйлдвэрлэлийн эрэлт тогтвортой байсан нь үнийг дэмжжээ.

III. ДОТООД ЭДИЙН ЗАСАГ

3.1. Эдийн засгийн өсөлт

2026 оны эхний таван сарын урьдчилсан гүйцэтгэлээр Монгол улсын эдийн засгийн өсөлт 7.3%-д хүрсэн нь өмнөх оны мөн үеийн 5.8%-ийн өсөлтөөс сайжирсан үзүүлэлт болж байна.

График 3 Монгол улсын эдийн засгийн өсөлт



Эх сурвалж:YCX

Ийнхүү өсөхөд уул уурхай, олборлолтын салбар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.2%-аар, хөдөө аж ахуйн салбар 11.5%-аар өссөн нь голлон нөлөөлжээ. Салбарын оролцооны хувиар авч үзэхэд нийт эдийн засгийн өсөлтийн 3.7 нэгж хувийг уул уурхай, олборлолтын салбар, 1.9 нэгж хувийг тээвэр, үйлчилгээний салбар бүрдүүлсэн бол удаалж 1.5 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбар дангаар бүрдүүлсэн байна [1]. Тодруулбал, зэс болон нүүрсний үйлдвэрлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад сэргэсэн нь уул уурхайн салбарын өсөлтийг голлон тайлбарласан хэвээр бөгөөд үүнтэй уялдан тээврийн салбар өмнөх оноос сэргэх хандлага ажиглагдаж байна.

Хүснэгт 2 Эдийн засгийн өсөлтөд салбаруудын оролцоо, 2026 оны эхний улирлын байдлаар

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, САЛБАРААР	Оролцоо	Жилийн өсөлт
ДНБ	**7.8%**	
ХАА	1.5%	11.5%
Уул уурхай, олборлолт	**3.7%**	**29.2%**
Үйлдвэрлэл, барилга	0.3%	2.6%
Үйлчилгээ	1.9%	4.0%
Бүтээгдэхүүний цэвэр татвар	-0.1%	-0.6%

[1] *Голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр авч үзэхэд өмнөх оны мөн үеэс нүүрсний олборлолт 44.2%-аар, харин зэсийн баяжмалын үйлдвэрлэл 21.3%-аар өссөн байна.*

3.2. Инфляц

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) 2026 оны 6 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.0%, өмнөх сараас 1%-аар тус тус өсөж, инфляцын дарамт үргэлжлэн нэмэгдсээр байна.

Жилийн инфляцыг бүрэлдэхүүнээр авч үзвэл өсөлтийн голлох дарамт хүнсний бүлгээс үүссэн хэвээр байна. Тухайлбал, хүнсний бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 24.8%-аар өсөж, нийт инфляцын 6.8 нэгж хувь буюу 56.4%-ийг бүрдүүлсэн нь хамгийн өндөр нөлөө үзүүлжээ. Үүнээс мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлт дангаараа инфляцад 4.8 нэгж хувийн нөлөө үзүүлсэн байна. Ялангуяа 2026 оны 6 дугаар сард үхрийн махны үнэ 57.1%, хонь, ямааны махны үнэ 60.0%-аар тус тус өссөнөөр мах, махан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 50.9%-аар нэмэгджээ.

График 4 Инфляц ба Бодлогын хүү



Эх сурвалж: Монголбанк, ҮСХ

Дотоодын хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтийн зэрэгцээ импортын барааны үнийн өсөлт инфляцыг нэмэгдүүлэхэд үргэлжлэн нөлөөлжээ. Нийт инфляцын 2.8 нэгж хувь буюу 22.9% нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Үүнээс бензин, түлшний үнийн өсөлт 0.9 нэгж хувь бол, бусад импортын барааны үнэ инфляцад 1.9 нэгж хувийн нөлөө үзүүлжээ. Төгрөгийн ханш харьцангуй тогтвортой хадгалагдаж байгаа ч дэлхийн бусад улс орнуудад инфляц эрчимжиж буй нь ийнхүү импортын үнийн өсөлтийг нэмэгдүүлэх эрсдэлтэй байгаа юм. Мөн орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ өмнөх сараас 3.6%-иар өссөн нь сарын инфляцын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Ийнхүү инфляц оны эхэнд Төв банкны зорилтот интервалтай ойролцоо түвшинд хадгалагдаж байсан хэдий ч хоёрдугаар улиралд эрчимжин өсөж, 2026 оны 6 дугаар сард 12.0%-д хүрлээ. Хэдийгээр нийлүүлэлтийн шинжтэй инфляцын дарамт давамгайлж байгаа ч зардлын сувгаар инфляц эрчимжих, инфляцын хүлээлт нэмэгдэхээс сэргийлэхэд Төв банкнаас мөнгөний бодлогын хатуу төлөвийг хадгалах хандлагатай байна.

3.3. Улсын төсөв

2026 оны эхний хагас жилд улсын нэгдсэн төсвийн орлого өссөн хэдий ч зарлага илүү хурдацтай нэмэгдсэнээр төсвийн алдагдал эрчимтэй тэллээ. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 14.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 10.7 хувиар өссөн бол нийт зарлага 16.8 их наяд төгрөг болж 20.0 хувиар өссөн байна. Үүний дүнд төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2.1 их наяд төгрөгийн алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийн 758.0 тэрбум төгрөгийн алдагдлаас 2.8 дахин нэмэгдлээ.

Төсвийн зардлын бүтцийн гол бүрэлдэхүүнээр авч үзвэл, 2026 оны эхний хагас жилд урсгал шилжүүлэг нийт зардлын 38.8 хувийг бүрдүүлж, өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өссөн байна. Мөн нийт зардлын 36.5 хувийг бүрдүүлж буй бараа, үйлчилгээний зардал 20.0 хувиар өссөн бол нийт зардлын 16.6 хувийг эзэлж буй хөрөнгийн зардал өмнөх оны мөн үеэс 58.2 хувиар огцом өссөн нь нийт зарлагын өсөлтийг бүрдүүлж буй гол хүчин зүйл болж байна.

График 5 Улсын төсөв



Эх сурвалж: УСХ

Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын бүтцийг харвал татварын нийт орлогын 29.9 хувийг орлогын албан татвар, 24.0 хувийг НӨАТ, 22.2 хувийг нийгмийн даатгалын орлого, 7.2 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 3.2 хувийг онцгой албан татвар, үлдсэн 13.5 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна. Тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 10.7 хувиар өсөхөд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ) 10.7 хувь, нийгмийн даатгалын орлого 16.2 хувь, НӨАТ-ын орлого 11.7 хувь, орлогын албан татварын орлого 7.2 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Харин онцгой албан татварын орлого 20.7 хувиар буурсан нь орлогын өсөлтийг сааруулах нөлөө үзүүлэв.

3.4. Мөнгөний нийлүүлэлт

2026 оны 6 дугаар сарын эцэст мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.6%-иар өсөж 53.4 их наяд төгрөгт хүрлээ. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг эх үүсвэр (пассив) талаас авч үзвэл, төгрөгийн хадгаламж 28.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 5.9 их наяд төгрөгөөр буюу 26.3%-иар өссөн бол төгрөгийн харилцах

12.6 их наяд төгрөгт хүрч 2.8 их наяд төгрөгөөр буюу 29.3%-иар, валютын харилцах 6.4 их наяд төгрөгт хүрч 2.7 их наяд төгрөгөөр буюу 75.4%-иар тус тус өссөн байна. Харин валютын хадгаламж 5.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 384.3 тэрбум төгрөгөөр буюу 7.1%-иар буурсан байна. Төгрөгийн хадгаламжийн 81.6%-ийг иргэдийн хадгаламж, 18.4%-ийг аж ахуйн нэгж, байгууллагын хадгаламж бүрдүүлж байна.

График 6 Мөнгөний нийлүүлэлт



Эх сурвалж: YCX

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд байршуулалт (актив) талаас гадаад цэвэр актив болон зээлийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, төлбөрийн тэнцэлийн ашигтай уялдан гадаад цэвэр актив 2026 оны 6 дугаар сарын эцэст 10.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.6 их наяд төгрөгөөр буюу 2.7 дахин өссөн байна. Түүнчлэн зээлийн өсөлт үргэлжилж, дотоод цэвэр актив 43.0 их наяд төгрөгт хүрч 4.7 их наяд төгрөгөөр буюу 12.2%-иар өссөн нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг дэмжжээ.

3.5. Нийт зээл

Нийт зээлийн үлдэгдэл 2026 оны 6-р сард 49.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.9 их наяд төгрөгөөр буюу 15.9%-аар өссөн бол өмнөх сараас 1.7 их наяд төгрөгөөр буюу 3.6%-аар өсчээ. Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 2.5%-иар буурч 2.4 их наяд төгрөгт хүрээд байгаа ч энэ нь өмнөх оны мөн үеэс 17.9%-иар өссөн дүн болж байна. Харин чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 5.0% байгаа бол анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл 1.2 их наяд төгрөг болж нийт зээлийн 2.5%-ийг бүрдүүлж байна.

Зээлийн бүтцийн хувьд нийт зээлийн 65.5% нь бизнесийн зээл, 23.7% нь хэрэглээний зээл, үлдсэн 10.7% нь банкны эх үүсвэрээр олгосон ипотекийн зээл байна. Өндөр хүүгийн орчин болон хатуу мөнгөний бодлогын нөлөөгөөр зээлийн өсөлт 2026 онд харьцангуй тогтвортой боловч өмнөх онуудтай харьцуулахад нам түвшинд хадгалагдаж байна. 2026 оны 6-р сарын байдлаар нийт зээлийн жилийн өсөлт 15.9%-д буйгаас хэрэглээний зээлийн өсөлт 9.3%-д хүрсэн бол бизнесийн зээлийн өсөлт 15.8%-д хүрч нийт зээлийн өсөлтийг голлон дэмжжээ.

График 7 Банкны салбарын зээл



Эх сурвалж: YCX

3.6. Гадаад худалдаа

2026 оны эхний зургаан сарын урьдчилсан гүйцэтгэлээр нийт экспорт 10,394 сая ам.доллар, нийт импорт 6,117 сая ам.долларт хүрч тус бүр харгалзан өмнөх оны мөн үеэс 57.9 хувь ба 10.7 хувиар өсжээ. Импортын өсөлтөд нефтийн бүтээгдэхүүний үнэ болон худалдан авалтын өсөлт голлон нөлөөлсөн хэвээр байгаа бол нүүрс, зэсийн хүдэр, баяжмалын экспортын өсөлтөөр нийт экспорт өндөр түвшинд хадгалагдаж байна. Улмаар худалдааны тэнцлийн ашиг 4,277 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.1 дахин өслөө.

График 8 Нийт экспорт, импорт



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Нийт экспортын 57.9 хувийн өсөлтийн 34.8 нэгж хувийг зэсийн баяжмалын орлогын өсөлт, харин 21.1 нэгж хувийг нүүрсний экспортын орлого тайлбарлаж байна.

Тухайлбал өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэсийн баяжмалын орлого хоёр дахин өссөн бол, нүүрсний экспортын орлого 54.2%-аар, мөн алтны экспортын орлого 9.1%-аар өсөөд байна.

График 9 Экспортын голлох бүтээгдэхүүн



Эх сурвалж: Монголбанк

Зэсийн баяжмалын биет хэмжээ эхний зургаан сард 1,306.9 мянган тоннд хүрсэн ба сарын цэвэр хилийн үнэ тонн тутамд 3,847 ам.доллар болж, өмнөх сараас өссөн төдийгүй өмнөх оны мөн үеэс 55.2 хувиар өндөр түвшинд хүрсэн байна. Монгол улсын зэсийн баяжмалын олборлолт өмнөх оны сүүлийн хагасаас эрчимтэй сэргэж, цаашид ч зэсийн үйлдвэрлэл өндөр түвшинд хадгалагдах төлөвтэй бөгөөд сэргээгдэх эрчим хүч, орчин үеийн боловсронгуй аж үйлдвэрлэл нь зэсийн эрэлтийг дэмжсэнээр дэлхийн зах зээл дэх зэсийн үнэ дунд хугацаанд өндөрт хадгалагдах төлөвтэй байна.

График 10 Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ, үнийн түвшин, 2026 6-р сар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Нүүрсний зах зээлд 6-р сард үнэ өсөх хандлага дахин ажиглагдлаа. Энэ нь 5-р сард БНХАУ-ын нүүрс олборлолтын гол бүс болох Шаньси мужийн нүүрсний уурхайд

гарсан ослын дараах аюулгүй ажиллагааны хяналт шалгалтыг эрчимжүүлснээс шалтгаалж Шаньси мужийн уурхайн нийлүүлэлт буурч, Хятадын дотоодын коксжих нүүрсний үнэ өссөнтэй холбоотой байв.

Улмаар Хятадын коксжих нүүрсний нийт импорт эхний зургаан сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 26.6%-иар өссөн бол Монгол улсаас импортлох хэмжээ 63.9%-иар өсжээ. Ийнхүү Монгол улсын экспортын нүүрсний хилийн дундаж үнэ 6-р сард тонн тутамд 74.7 ам.долларт хүрч, өмнөх сараас 2.7 ам.доллароор нэмэгдсэн байна. Мөн нүүрсний экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 62 хувиар өсөж 56.8 сая тоннд хүрсэн бөгөөд экспортын орлого 3.9 тэрбум ам.долларыг давж, нийт экспортын орлогын 37.9 хувийг бүрдүүлжээ.

Түүнчлэн Монгол Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн барилгын ажил 33 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байгаа бөгөөд 2027 оны 4 дүгээр сард ашиглалтад орохоор төлөвлөж байна. Тухайн төмөр зам нь Тавантолгой–Гашуунсухайт чиглэлийн төмөр замын үргэлжлэл болж, ашиглалтад орсноор нүүрсний экспортын хэмжээг нэмэгдүүлэх, боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулах, тээврийн зардлыг бууруулах зэрэг эерэг нөлөө үзүүлэхээр байна. Иймд дунд хугацаанд Монголын нүүрсний экспортын өрсөлдөх чадвар нэмэгдэж, БНХАУ-ын зах зээлд нийлүүлэх хэмжээ өсөх хүлээлттэй байна (Sxcoal, 2026).

График 11 Чулуун нүүрсний экспортын биет хэмжээ, үнийн түвшин, 2026 6-р сар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Харин импортын зардлын задаргааны хувьд нефтийн бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 38.7%-аар өссөн бол суудлын болон ачааны автомашины импорт өмнөх оны мөн үеэс буурсан хэвээр байна. Нефтийн бүтээгдэхүүний өсөлтийг бүрэлдэхүүн хэсгээр авч үзэхэд нийт өсөлтийн 30.4 нэгж хувийг зуны дизель түлш, харин 7.6 нэгж хувийг АИ 92 бензиний худалдан авалт голлон бүрдүүлжээ.

График 12 Импортын голлох бүтээгдэхүүн



Эх сурвалж: : Гаалийн Ерөнхий Газар

3.7. Төлбөрийн тэнцэл, ханш

2026 он гарснаас хойш гадаад худалдааны ашигтай холбоотойгоор урсгал дансны хуримтлагдсан ашиг нэмэгдэж байсан ч 5-р сарын байдлаар 47 сая ам.долларын алдагдалтай гарчээ. Үүнд урсгал дансны анхдагч орлогын данс дахь гадаад өр төлбөрт төлсөн хүүгийн төлбөр голлон нөлөөлөв. Харин дотоодын хувийн хэвшлүүдийн гадаад зах зээлээс босгосон бондын эх үүсвэр нэмэгдсэн нь цэвэр орох урсгалыг дэмжиж, санхүүгийн данс ашигтай гарахад нөлөөлж байна.

Ийнхүү төлбөрийн тэнцэл 2026 оны 5-р сарын байдлаар 537 сая ам.долларын ашигтай гарч, гадаад валютын албан нөөц (ГВАН) өндөр түвшинд хадгалагдаж байна. ГВАН 6-р сарын шинэчлэгдсэн статистикаар 7.66 тэрбум ам.доллар буюу импортын 8 сарыг хэрэгцээг хангах түвшинд хадгалагдаж байгаа нь төгрөгийн ханш тогтвортой хадгалагдах суурь нөхцөлийг бий болгож байна. Тухайлбал төгрөгийн албан ханш 6-р сарын эцэст 3,581 төгрөг/ам.доллартай тэнцэж буй бөгөөд цаашид төлбөрийн тэнцэл, валютын орох болон гарах урсгалд гарах өөрчлөлтөөс шалтгаалан ханшийн төлөв тодорхойлогдохоор байна.

График 13 *Төлбөрийн тэнцэл*





Эх сурвалж: Монголбанк

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

7575-1111 /1277/
eru@golomtbank.com
www.dua.golomtbank.com

Голомт банкны төв байр,
Сүхбаатарын талбай 5, Ш/х-22,
Улаанбаатар 15160, Монгол Улс
SWIFT: GLMT MNUB

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны хэлтэс нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.